



**ИХ ГАЗРЫН ЧУЛУУНЫ БАЙГАЛИЙН
ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/17

Сайнцагаан сум

Гэрээ байгуулж, ажил гүйцэтгүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.6 дахь заалт, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/159, 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/73 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Их газрын чулууны ууланд орцын хаалга, зүг чиг заасан, хориглосон тэмдэг, танилцуулга самбар, хогийн сав хийх ажлыг гүйцэтгүүлэхээр Ашид бьюлдинг ХХК-тай 4500000 (Дөрвөн сая таван зуун мянган) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зургийн дагуу ажлыг чанартай хийж гүйцэтгэх хүлээлгэн өгөхийг Ашид бьюлдинг ХХК-ны захирал /О.Мөнхсаруул/-д үүрэг болгосугай.

Гурав. Ажлын гүйцэтгэлд гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг байгаль хамгаалагч /Д.Мөнх-Очир/-т үүрэг болгосугай.

Дөрөв. Дээрх ажилд шаардагдах хөрөнгө 4500000 (Дөрвөн сая таван зуун мянган) төгрөгийг байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Б.Цэрэнмягмар/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Р.БАТТҮВШИН

Их газрын чулууны байгалийн цогцолборт
газрын хамгаалалтын захиргааны даргын
2018 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн
..... тоот тушаалын хавсралт

Хийгдэх ажлын жагсаалт

№	Хийгдэх ажил	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ/мян.төг/	Нийт дүн/мян.төг/
1	Орц хаалга	1	750000	750000
2	Танилцуулга самбар	4	180000	720000
3	Зүг чиг заасан тэмдэг	6	50000	300000
4	Хориглосон тэмдэг	12	50000	600000
5	Хогийн сав /Төмөр/	2	300000	600000
6	Био 00	1	1530000	1530000
Дүн			4500000	